



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

**ТЕНДЕРИЙН СОНИРХОГЧ
ЭТГЭЭДЭД**

2024.12.05 № 03/2051

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Хөшигийн хөндий туннел” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга хүссэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна.

Д/д	Оролцогчийн тодруулга	Тодруулгын хариу
1	Гадаадын банканд тендерийн баталгаа гаргахад Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг англи хэлээр орчуулж өгөх шаардлага тавьсан учир албан ёсоор орчуулгыг өгнө үү.	Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 12.1 дэх заалтад заасны дагуу Тендерийн баримт бичиг Монгол хэлээр байна гэж заасан тул тендерийн сонирхогч этгээд нь албан ёсны эрхтэй орчуулгын байгууллагаар орчуулгыг хийлгэхийг зөвлөж байна.
2	Тендерийн баталгааг захиалагчийн дансанд байршуулахгүйгээр монгол дахь банк баталгаа гарган цахим системд мэдээлэл оруулж ажиллах нь зөвүү?	Төрийн худалдан авах цахим систем https://www.tender.gov.mn/mn/rules/list - д байршуулсан тендерийн баталгааны журмыг баримтална.
3	Манай компани тус тендерт оролцож байгаа бөгөөд Монгол Улсын хуулийн дагуу манай улсын банкнуудад Монгол Улсын арилжааны банк руу SWIFT ашиглан бидний гаргуулж байгаа тендерийн баталгааг илгээх боломжгүй байгаа тул бид банканд гаргуулсан тендерийн баталгаагаа Монгол Улсын Төрийн худалдан авах ажиллагааны газраар дамжуулан цахим системээр ирүүлж болох уу? Энэхүү тендерт гаргуулж буй тендерийн баталгааг хүлээн авч	Төрийн худалдан авах цахим систем https://www.tender.gov.mn/mn/rules/list - д байршуулсан тендерийн баталгааны журмыг баримтална. Хууль болон журмаар зохицуулахааргүй нөхцөл үүссэн тохиолдолд тендерийн сонирхогч этгээдээс Төрийн худалдан авах ажиллагааны газарт хандан асуудлыг шийдвэрлүүлнэ үү.

	цахим системд байршуулах тухай Монгол Улсын Төрийн худалдан авах ажиллагааны газарт мэдээлж өгнө үү.	
--	--	--

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.